



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 05 сарын 13 өдөр

Дугаар А/107

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 5.4.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Буянт-Ухаа дахь В-2, В-8 постуудын дээврийн болон бусад засварын ажил хийж гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга:

Б.Оргил

“Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын тэргүүн дэд захирал

Нарийн бичгийн дарга:

Ч.Чимэдноров

Худалдан авах ажиллагааны тасгийн мэргэжилтэн

Гишүүд:

Г.Наранчимэг

Нисэх буудлуудын үйлчилгээний газрын мэргэжилтэн

О.Тэмүгэ

Иргэний нисэхийн залуучуудын холбооны гишүүн

П.Шинэбаяр

“Монгол Улсын өрөмдлөгийн холбоо” Төрийн бус байгууллагын гишүүн

2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо (Б.Оргил)-нд үүрэг болгосугай.

3. Тендер болон сонгон шалгаруулалттай холбоотой баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, тендер нээхэд Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Хуулийн хэлтэст хүргүүлэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Ч.Чимэдноров)-д даалгасугай.

ДАРГА



П.МӨНХЖАРГАЛ

1721 01 0848